



Ерөнхий Ассамблей

2006 оны 4 сарын 3

60-р чуулган

Ерөнхий Ассамблейгаар батлагдав.

60/251. Хүний эрхийн зөвлөл

Ерөнхий Ассамблей,

Ард түмнүүдийн өөртөө засан тогтнох болон тэгш эрхийн зарчмыг хүндэтгэн улс үндэстнүүдийн хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засаг, нийгэм, соёл болон хүмүүнлэгийн асуудлаар олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрх үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх зэрэг НҮБ-ын зорилго, зарчмыг дахин нотлон,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Венийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөр, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон хүний эрхийн бусад гэрээ хэлэлцээрүүдийг үндэслэн, дахин нотлон,

Түүнчлэн хүний бүх эрх нь түгээмэл, хуваагдашгүй, бие даасан бөгөөд харилцан хамааралтай, аль нэг нь хэрэгжихгүйгээр бусад хэрэгжих боломжгүй бөгөөд хүний бүх эрх, эрх чөлөөг адил тэгш үзэж, хандах ёстойг дахин нотолж,

Үндэсний болон бүсийн онцлог байдал, түүх, соёл, шашны олон янзын уламжлал чухал боловч бүх улсууд улс төр, эдийн засаг, соёлын тогтолцооноос үл хамааран хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах хамгаалах үүрэгтэйг онцлон тэмдэглэж,

НҮБ-ын дүрэмд заасны дагуу улс орон бүр хүний эрх, эрх чөлөөг арьс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, язгуур угсаа, бусад ялгааг эс харгалзан ямар ч ялгаваргүйгээр хүндэтгэх үүрэгтэйг онцлон,

Энх тайван, аюулгүй байдал, хөгжил ба хүний эрх нь НҮБ-ын тогтолцооны үндсэн тулгуур хамтын аюулгүй байдал, сайн сайхан амьдралын үндэс суурь бөгөөд эдгээр нь харилцан хамааралтай, аль нэг нь хэрэгжихгүйгээр бусад нь биелэх боломжгүйг хүлээн зөвшөөрч,

Бүх улсууд соёл, иргэншил, шашин хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлэх талаарх идэвхи чармайлтаа үргэжлүүлэх хэрэгтэйг сануулан бүсийн болон төрийн бус, шашны байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн хүлээцтэй байдал, үзэл бодол, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэхэд маш чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрч,

Хүний эрхийн комиссын хийж гүйцэтгэсэн ажлыг анхааралдаа авч, ололт амжилтыг нь уламжлан үргэлжлүүлэх, алдаа дутагдлыг засан сайжруулах хэрэгтэйг хүлээн зөвшөөрч,

Хүний эрхийн асуудлыг хэлэлцэхдээ түгээмэл шинж, бодит байдалд анхаарч, улстөржсөн сонголт хийх ёсгүй бөгөөд улс төржих, ялгавартай хандлагыг зогсоохын чухлыг анхааран,

Түүнчлэн хүний эрхийг хангах, хамгаалах явдал нь харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд суурилах ёстой бөгөөд хүн төрөлхтөний сайн сайхны тулд хүний эрхийн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх Гишүүн улсуудын чадавхийг дэмжих шаардлагатайг чухалчилж,

Үндэсний болон бүсийн, олон улсын хэмжээнд хүний эрхийг хангах, хамгаалахад төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж буйг хүлээн зөвшөөрч,

Хүн бүр иргэний болон улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, түүний дотор хөгжих эрхээ баталгаатай эдлэх явдлыг хангахын тулд НҮБ-ын хүний эрхийн тогтолцоог бэхжүүлэх амлалтаа хэрэгжүүлэн Хүний эрхийн зөвлөлийг байгуулахаар шийдвэрлэж байна.

1. Хүний эрхийн комиссын оронд Женев хотноо байрлах Хүний эрхийн Зөвлөлийг Ерөнхий Ассамблейн салбар байгууллага болгон байгуулахаар шийдвэрлэв. Хүний эрхийн зөвлөлийн статусыг Ерөнхий Ассамблей 5 жилийн хугацаанд хэлэлцэнэ.
2. Хүний эрхийн зөвлөл нь хүний бүх үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаваргүйгээр, адил тэгш байдлаар хамгаалах үүрэг хариуцлагатай байхаар шийдвэрлэв.
3. Хүний эрхийн зөвлөл нь хүний эрхийн ужиг болон ноцтой зөрчлүүдийг үүсгэж буй нөхцөл байдлыг арилгах талаар зөвлөмж гаргана. Мөн НҮБ-ын системд хүний эрхийн идэвхитэй үйл ажиллагаа, зохицуулалтыг хөхүүлэн дэмжигч нь байх ёстой.
4. Хүний эрхийн зөвлөл нь үйл ажиллагаандаа түгээмэл, шударга байх, чиглэл зорилготой байх, урьдчилан сонгохгүй байх, харилцан ойлголцож хамтран ажиллах, тодорхой, уян хатан байх, ил тод, хариуцлагатай байх, тэнцвэртэй байх, хүртээмжтэй, олон талт байх, хүйсийн тэгш байдлыг хүндэтгэх, зарчмуудыг баримталж, иргэний болон улс төрийн эрх, хөгжих эрхийг оролцуулан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах, хамгаалахын төлөө ажиллана.
5. Хүний эрхийн зөвлөл нь:
 - (а) Хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжин, тухайн Гишүүн улстай зөвшилцсөний үндсэн дээр техникийн тусламж үзүүлэн чадавхийг нь бэхжүүлнэ.
 - (б) Хүний эрхийн тодорхой асуудлуудыг хэлэлцэх индэр болж ажиллана.
 - (в) Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр Ерөнхий Ассамблейд хандан зөвлөмж гаргана.

- (г) Улс орнуудын авсан хүний эрхийн үүрэг болон НҮБ-ын дээд хэмжээний уулзалт, хурлаас гарсан хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн зорилт, амлалт, үүргийн хэрэгжилтийг дэмжих үүрэгтэй.
- (д) Үнэн бодит мэдээлэл дээр үндэслэн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийг явуулна. Ингэхдээ хүний эрхийн бүх асуудлыг хамрах ба бүх улсуудад адил тэгш хандана. Дүгнэлт хэлэлцүүлэг нь хэлэлцүүлэгт орж байгаа улсын оролцоог хангасан, харилцан ярианд тулгуурлах хамтын механизм бөгөөд хэлэлцүүлэгт орж байгаа улсын чадавхиа бэхжүүлэх хэрэгцээ, шаардлагыг мөн авч үзнэ. Энэ механизм нь бие даасан бүтэц бөгөөд гэрээний хороодын үйл ажиллагаатай давхардахгүй. Хүний эрхийн зөвлөл нь үйл ажиллагаагаа эхэлснээс хойш нэг жилийн дотор Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн журам болон хугацааг тогтоон батлах болно.
- (е) Яриа хэлэлцээ, хамтын ажиллагаагаараа хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах ба хүний эрхийн онцгой нөхцөл байдалд яаралтай хариу арга хэмжээ авна.
- (ё) Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 сарын 20-ны өдрийн 48/141 тоот тогтоолын дагуу Хүний эрхийн дээд комиссартай холбоотой Хүний эрхийн комиссын үүрэг, хариуцлагыг хүлээн авч үргэлжлүүлнэ.
- (ж) Хүний эрхийн салбарт Засгийн газар, бүсийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд болон иргэний нийгэмтэй нягт хамтран ажиллана.
- (з) Хүний эрхийг хангах, хамгаалах талаар зөвлөмж гаргана.
- (и) Жил бүр үйл ажиллагаагаа Ерөнхий Ассамблейд тайлагнана.
6. Хүний эрхийн зөвлөл нь тусгай хэрэгслүүд, гомдол хянан шийдвэрлэх механизмыг хэвийн ажиллуулахын тулд Хүний эрхийн комиссын чиг үүрэг хариуцлага, механизмыг өвлөн авч, дүгнэн үзээд шаардлагатай бол өөрчилж, сайжруулна. Зөвлөл эхний хуралдаанаа хийснээс хойш нэг жилийн дотор энэхүү үнэлэлт, дүгнэлтийг хийсэн байна.
7. Хүний эрхийн зөвлөл нь нууц санал хураалтаар Ерөнхий Ассамблейн гишүүдийн олонхоос шууд сонгогдсон 47 Гишүүн улсаас бүрдэнэ. Гишүүнчлэл нь газар зүйн бүсийн төлөөллийг тэнцвэртэй хангасан байх ба нэг бүсээс орох төлөөллийн тоо нь дараахь байдалтай байна. Африкаас 13, Азиас 13, Зүүн Европоос 6, Латин Америк болон Карибын улсуудаас 8, Баруун Европ болон бусад улсуудаас 7 төлөөлөгч тус тус сонгогдоно. Гишүүнчлэлийн хугацаа 3 жил байх бөгөөд 2 дахиа улиран сонгогдсоны дараа дахин шууд сонгогдож болохгүй.
8. НҮБ-ын гишүүн бүх улс Хүний эрхийн зөвлөлийн гишүүн байж болно. Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдохдоо хүний эрхийг хангах, хамгаалах асуудалд онцгой анхаарч, тодорхой хувь нэмэр оруулахыг анхаарах бөгөөд сайн дурын үүрэг, амлалт авах үүрэгтэй. Ерөнхий Ассамблейн хуралд оролцож, санал өгсөн гишүүдийн гуравны хоёрын саналаар Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийг сонгох ба хүний эрхийн ноцтой зөрчил гарсан бол гишүүнээс хасаж болно.

9. Хүний эрхийн зөвлөлийн гишүүд нь гишүүнийхээ хугацаанд хүний эрхийг хангах, хамгаалахад дээд зэргээр анхаарах бөгөөд Зөвлөлтэй байнга холбоотой ажиллана. Түүнчлэн гишүүнчлэлийнхээ хугацаанд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт орсон байна.
10. Хүний эрхийн зөвлөл нь жилийн турш байнгын ажиллагаатай байх бөгөөд жилд 10 долоо хоногоос доошгүй хугацаагаар, гол хуралдааныг оролцуулан гурваас доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн гишүүдийн гуравны нэгийн саналаар тусгай хуралдаан хийнэ.
11. Ерөнхий Ассамблей болон Зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол Зөвлөл нь үйл ажиллагаандаа Ерөнхий Ассамблейн хороодын үйл ажиллагааны журмыг баримтална. Ажиглагч улсууд, ялангуяа Зөвлөлийн гишүүн бус улсууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон засгийн газар хоорондын бусад байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай харилцах, тэдний оролцоог хангахад Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1996 оны 7 сарын 25-ны өдрийн 1996/31 тоот тогтоолоор баталсан журам ба Хүний эрхийн комиссын үйл ажиллагаанд тогтсон практикийг дагаж мөрдөнө. Ингэхдээ эдгээр байгууллагуудад үр дүнтэй хувь нэмрээ оруулах боломж олгоход анхаарна.
12. Зөвлөлийн үйл ажиллагааны арга барил нь ил тод нээлттэй, шударга байх, үр дүнтэй харилцан яриа хэлэлцээрийг эрхэмлэх, үр дүнд чиглэсэн, тогтоол шийдвэрийнхээ хэрэгжилтийг анхаарч, дүгнэлт хэлэлцүүлэг явуулдаг байх болон тусгай үүрэг гүйцэтгэгчидтэй байнгын харилцаатай байх зэрэг болно.
13. 2006 оны 6 сарын 16-нд болон өөрийн 62 дахь хуралдаанаараа үйл ажиллагаагаа дуусгавар болгохыг Хүний эрхийн комиссоос шаардахыг Эдийн засаг, нийгэм, соёлын зөвлөлд даалгасугай.
14. Хүний эрхийн зөвлөлийн анхны гишүүдийг сонгохоор шийдвэрлэв. Эхний удаа газар зүйн бүсийн төлөөллийг тэнцвэртэй хангахад анхааран сугалаагаар сонгосон тул гишүүнчлэлийн хугацаа өөр байж болно
15. 2006 оны 5 сарын 9-нд Хүний эрхийн зөвлөлийн анхны гишүүдийг сонгох ба 2006 оны 6 сарын 19-нд Зөвлөлийн эхний хуралдаан болно.
16. Байгуулагдсанаас хойш 5 жилийн дараа өөрийн үйл ажиллагаагаа үнэлэн дүгнэж, Ерөнхий Ассамблейд тайлагнахыг Хүний эрхийн зөвлөлд даалгасугай.

72 дугаар нэгдсэн чуулган

2006 оны 3 сарын 15